

Эцэг эхчүүд гэртээ хүүхдийнхээ суралцах явцад туслах нь

Эцэг эх, асран хамгаалагч нарт зориулсан мэдээлэл

Сургуульд сурч байгаа мэдлэг чадварыг нь бататгахын тулд таны хүүхдэд гэртээ хийж гүйцэтгэвэл зохих даалгавруудыг бид өгөх болно.

Хүүхдээ уг даалгаврыг хийж дуусгахыг нь урамшуулж, тэдэнтэй энэ талаар нь ярилцаж байгаарай. Хүүхдээ ингэж дэмжсэнээр та хүүхдийнхээ сургуульдаа сурч эзэмшиж байгаа зүйлийнх нь талаар ойлголттой болохоос гадна таныг сурах явц, боловсролыг чухалчилдаг гэдгийг хүүхэд тань ойлгож мэдэх болно.

Даалгавраа гэртээ хийж гүйцэтгэх нь таны хүүхдэд дараах боломжийг олгоно:

- сургууль дээр сурсан зүйлээ дахин сэргээн санах,
- хичээлийн ойлгох болон суралцах ур чадварыг бэхжүүлэх,
- ирээдүйд насан туршид нь хэрэг болох суралцах чадварыг хөгжүүлэх.

Сайн зуршлыг гэртээ бий болгох

Хүүхэд сайн зуршилтай болох нь ирээдүйд түүний сургууль болон ажил хөдөлмөрт нь насан туршид туслах болно.

- Даалгавраа хийж дуусгах тогтмол цагийг тогтоож өгөх. Энэ нь өдөр бүр ижил цаг байвал зохино.
- Хүүхэддээ хамгийн тохиромжтой цагийг сонгох (зарим хүүхэд өглөө, зарим нь үдээс хойш илүү анхаарлаа төвлөрүүлж чаддаг).

Тав тухтай орон зай олговол энэ нь таны хүүхдэд илүү хялбар байх болно.

- Чимээ шуугиангүй, гэрэлтүүлэг сайтай газар хүүхэддээ зориулан бий болгоорой.
- Харандаа, цаас, компьютер гэх мэт хэрэгцээтэй зүйлсийг нь ойрхон байлгана уу.
- Анхаарал сарниулах зүйлсийг хол байлгаарай (жишээлбэл, зурагт, компьютер тоглоомоос хол байлгах).

Би хүүхэддээ яаж туслах вэ?

- Тэдний хийж байгаа зүйлийн талаар асууж энэ талаар сонирхож байгаагаа илэрхийлээрэй.
- Сурч байгаа зүйлээ зааж өгөхийг хүүхдээсээ хүсээрэй.
- Тэдэнд тусламж хэрэгтэй эсэхийг шалгана уу.
- Тухайн даалгаврыг хийх оролдлого гаргах, мөн хийж дуусгах үед нь хүүхдийнхээ чармайлт, хичээл зүтгэлийг магтаарай.
- Эцэг эх, асран хамгаалагчдад дэмжлэг үзүүлж чадах бусад материал, эх сурвалжуудыг хэрхэн хаанаас авч болохыг багшаас нь асуугаарай.

Гэртээ гэрийн даалгавар хийх нь таны хүүхдийн хувьд эерэг туршлага байх ёстой гэдгийг санаарай.

Хэрэв хүүхдэд тань нэмэлт тусламж эсвэл тусгайлан өөрчлөлт хийх шаардлагатай бол багшид нь мэдэгдээрэй.

Утсан Орчуулгын Үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний орчуулагч хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.